

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

ХУУЛИЙН ЭТГЭЭД

17.1. Кибер орчинд дундын мэдээллийн системээр дамжуулан мэдээлэл боловсруулах, хадгалах, түгээх, цахим тооцооллын болон түүний хэвийн үйл ажиллагааг хангахад мэдээллийн технологийн чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээд

17.1.1. Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам баталж, мөрдөх;

17.1.5. Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа хариуцсан нэгж, эсхүл албан тушаалтантай байх;

17.1.6. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хоёр жил тутамд, холбогдох журамд заасан нөхцөл, байдал үүссэн үед тухай бүр хийлгэж, гарсан дүгнэлт, зөвлөмж, шаардлагын дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

17.3. Энэ хуулийн 17.1-д зааснаас бусад хуулийн этгээд

17.3.1. Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам баталж, мөрдөх;

17.3.2. Кибер халдлага, зөрчлийн талаар кибер халдлага, зөрчилтэй тэмцэх холбогдох төвд мэдэгдэх, шаардлагатай үед туслалцаа авах;

17.3.3. Эрх бүхий байгууллагаас хүргүүлсэн зөвлөмжийг дагах, шаардлагыг биелүүлэх;

ОНЦ ЧУХАЛ МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЭЦТЭЙ БАЙГУУЛЛАГА

4.1.12. Кибер аюулгүй байдал алдагдсанаар хэвийн үйл ажиллагаа нь доголдож Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засагт хохирол учруулж болох мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ бүхий байгууллага

19.2.1. Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам баталж, мөрдөх;

19.2.2. Кибер халдлага, зөрчлийн үед дагаж мөрдөх төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх;

19.2.3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар стандартыг нэвтрүүлэх;

19.2.4. Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа хариуцсан нэгж, эсхүл албан тушаалтантай байх;

19.2.5. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг жил тутамд, эсхүл мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний өөрчлөлт хийгдэх бүрд хэсэгчлэн, эрх бүхий байгууллагын шаардсанаар тухай бүр хийлгэж, гарсан дүгнэлт, зөвлөмж, шаардлагын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

19.2.13. Хариуцсан мэдээллийн систем, дэд бүтцийн хэвийн, найдвартай, тасралтгүй байдлыг хангах, гэмтэл саатлын үед сэргээн ажиллуулах төлөвлөгөөтэй байх;

ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан байгууллага

16.1.1. Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам баталж, мөрдөх;

16.1.2. Кибер аюулгүй байдлыг хангах талаар эрх бүхий байгууллагаас өгсөн зөвлөмж, шаардлагыг биелүүлэх;

16.1.3. Кибер халдлага, зөрчилд өртсөн, өртсөн байж болзошгүй тохиолдолд кибер халдлага, зөрчилтэй тэмцэх холбогдох төвд даруй мэдэгдэх;

16.1.4. Кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах хөрөнгө, үйл ажиллагааны зардлыг төсөвт жил бүр тусгах;

ОНЦ ЧУХАЛ МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЭЦТЭЙ БАЙГУУЛЛАГА

ЭРЧИМ ХҮЧ, УС, ДУЛААН, ЭРҮҮЛ МЭНД, БАНК, САНХҮҮ, ХАРИЛЦАА ХОЛБОО, ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН СИСТЕМ, ДАТА ТӨВ, ХИЛИЙН ХЯНАЛТ, СТРАТЕГИЙН ХҮНС, ШАТАХУУН. ГЭХ МЭТ ХУУЛЬД ЗААСАН БАЙГУУЛЛАГУУД

113[®] Кибер халдлагын үед

113.mn

- Дариу мэдэгдэх
- Таслан зогсоох туслалцаа авах боломжгүй бол
- Үйл ажиллагаа доголдсон бол яаралтай мэдээлэх
- Эрх бүхий байгууллагын зөвлөмж, шаардлагыг биелүүлэх

Эрсдэлийн үнэлгээ ба аудит

pubcert.mn

- Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ (2 жил тутам)
- Мэдээллийн аюулгүй байдлын аудит (жил тутам / хуульд зааснаар)
- Гарсан дүгнэлт, зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Тайланг 1 сарын дотор КХЗТН-д хүргүүлэх